



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/412

Улаанбаатар хот

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын
газрын хөрөнгийг данснаас дансанд
шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу 81,863,144 (наян нэгэн сая найман зуун жаран гурван мянга нэг зуун дөчин дөрөв) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (Л.Эрдэнэчулуун)-т зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (Л.Эрдэнэчулуун)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001123

